


Монголын Алтайн уул дахь мал маллагааны менежмент түүний бүтээгдэхүүн үйлдвэрлэл дэх улирлын нүүдлийн үүрэг



www.watercope.org



Ц.Мөнхнасан¹, Eva Schlecht², Н.Тогтохбаяр¹

¹Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль

²Герман улсын Касселийн их сургууль

Таамаглал

- Өнөөгийн мал маллагааны менежмент, бэлчээр ашиглалтын арга нь газрын доройтол, уст цэгийн хомсдолыг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг бууруулж байна.
- Өндөр уулын бэлчээрт ургаж буй ургамлын ургац, түүний тэжээллэг чанар нь их хэмжээний мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж олгохгүй байна.
- Бэлчээр дэх уст цэгийг сайжруулж мал маллагааны арга технологийг боловсронгуй болгосноор мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой.

Зорилго, зорилт

Дээрхи таамаглалд үндэслэн мал аж ахуйн бүтээгдэхүүн түүний нөхөн үйлдвэрлэл болон бэлчээрийн ургамлын тэжээллэгт чанарт үзүүлж буй газар ашиглалт, мал аж ахуйн менежментийн өөрчлөлтийн нөлөөг үнэлэхэд энэхүү судлагааны зорилго оршиж байна.

Энэхүү судалгааны үр дүнд зорилтот бүс нутагт зориулсан тогтвортой мал аж ахуй ба бэлчээрийн менежментийн стратегийг тодорхойлох болно.

Зорилтууд:

- Малчин өрхийн мал маллагааны арга технологийг тодорхойлох;
- Малын ашиг шим болон өнөөгийн тэжээллэгийн нөхцөл байдлыг тодорхойлох;
- Малын бэлчээрлэлтийн зан төрх, бэлчээрлэлтийн маршрутыг тодорхойлох;
- Экологи, эдийн засгийн нөлөөллийг зохицуулахыг хичээх замаар мал маллагааны өнөөгийн менежмент болон тэжээлийн нөөцийн ашиг шим, бүтээгдэхүүн болж хувирах явцад үнэлгээ өгөх.



Зураг 2. Бэлчээрлэлтийн маршрутын дагуух бэлчээрийн ургамлын үнэлгээ хийж байгаа нь



Зураг1. Хоргол цуглуулах уут болон GPS багажаар тоногдсон туршилтын хонь бэлчээрлэж байгаа нь

Материал арга зүй



Зураг 3. Судалгааны материал цуглуулах арга ба докторын ажлын үндсэн бүлгүүд (зууван хүрээнд), дээжний бшинжилгээни үр дүнгүүд (дөрвөлжин хүрээнд)

Хүснэгт 1. Судалгааны материал цуглуулж шинжилгээ хийн докторын ажил бичих ажлын бүдүүвч

Хугацаа	Хийгдэх ажлууд
06 – 09 / 2012	125 өрхөөс санал асуулга авах
01 – 03 / 2013	Санал асуулгын дүнд анхан шатны боловсруулалт хийж бцаашид судалгаа хийх малчин өрх сонгох Хээрийн судалгаа: Тэжээлийн идэмж, бэлчээрлэлтийн маршрут (Зур.1), бэлчээрлэлтийн зан төрх, биомассын үнэлгээ (Зур. 2) болон ямаан сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд.
05 – 09 / 2013	Тоон мэдээлэлд боловсруулалт хийх, дээжийг лабораторт шинжлэх, докторын ажлын эхний бүлгийг бичих Хээрийн судалгаа: Тэжээлийн идэмж, бэлчээрлэлтийн маршрут (Зур.1), бэлчээрлэлтийн зан төрх, биомассын үнэлгээ (Зур.2) болон ямаан сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд; хонь болон ямааны амьдын жин тодорхойлох.
12 / 2013 – 04 / 2014	Тоон мэдээлэлд боловсруулалт хийх, дээжийг лабораторт шинжлэх, докторын ажлын 2 ба 3 дугаар бүлгийг бичих (Зур. 3)
06 – 09 / 2014	Докторын ажлын удиртгал, шүүн хэлэлцэхүй бүлгийг бичих
10 / 2014 – 06 / 2015	Докторын ажлын удиртгал, шүүн хэлэлцэхүй бүлгийг бичих
07 – 10 / 2015	Докторын ажлын удиртгал, шүүн хэлэлцэхүй бүлгийг бичих
12 / 2015	Докторын ажил хамгаалах

